Зам, тээврийн хөгжлийн яамны
2024 оны 07 дугаар сарын 09-ны
өдрийн 03/2981 дугаар албан
бичгийн хавсралт

9020050420 5919487 СБА7589

## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРТ 2024 ОНД ХИЙХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 07 дугаар сарын 08 — Улаанбаатар хот

| № | Аудитад хамрагдах байгууллага | Аудитын ажлын хамрах хүрээ | Аудит хийх хугацаа | Гүйцэтгэх хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **1.Төлөвлөгөөт дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт** | | | | | |
| 1 | Яамны аппарат | 2023-2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх | I улиралд | 15 хоног | Яамны аппаратын шилэн дансны хөтлөлтийн явцад холбогдох хуулийн дагуу тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 02 дугаар хагаст дотоод аудит хийхээр бэлтгэж байна. |
| 2 | “Иргэний нисэхийн үндэсний төв” ААТҮГ-ын “Жаргалант” амралт, спорт цогцолбор | 2023-2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаа | I улиралд | 15 хоног | Тус байгууллагын бүтэц 2024 оны 01 дүгээр улиралд өөрчлөгдөн Амралт, Спорт төв болон 2 салсан тул 2024 оны 02 дугаар хагаст дотоод аудит хийхээр төлөвлөөд байна. |
| 3 | “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл”, “Улаанбаатар-Дархан чиглэлд 2 эгнээ авто зам барих төсөл” | 2023-2024 оны авто замын салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа | I улиралд | 66 хоног | Сайдын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу 2 төслийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн. |
| 4 | Яамны аппарат | 2023-2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаа | III улиралд | 15 хоног | Хугацаа болоогүй. |
| 5 | Харьяа байгууллагууд | 2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | III улиралд | 15 хоног | 1.Сайдын эрхлэх асуудлын хүрээний 87 байгууллагын 2024 оны 01 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Сангийн яаманд 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10/1796 дугаар албан бичгээр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хүргүүлсэн. 01 дүгээр улирлын байдлаар хэрэгжилт 97.9 хувьтай байна. Хэрэгжилт хангалтгүй 5 байгууллагад албан бичиг хүргүүлэн ажилласан.<br><br>2.2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар шилэн данс хөтлөлттэй холбоотой илэрсэн алдаа, зөрчлийг бууруулах үүднээс 2024 оны 02 дугаар улирлаас эхлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг давтамжаар авахаас гадна цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхийн мөнгөн орлого, зарлагын гүйлгээ, хөрөнгийн болон урсгал зардал тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, төсөв хөрөнгө мөнгө захиран зарцуулсан тушаал шийдвэрийн мэдээллийг тоо, мөнгөн дүнгээр авах болсон талаар харьяа байгууллагуудад 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 10/2041 дүгээр албан бичгийг хүргүүлсэн.<br><br>3.Шилэн дансанд бүртгэлгүй 2 байгууллагыг бүртгүүлсэн байна. |
| 6 | “Булган АЗЗА” ТӨХК | 2023-2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаа | IV улиралд | 15 хоног | Хугацаа болоогүй. |
| 7 | “Дархан АЗЗА” ТӨХК | 2023-2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаа | IV улиралд | 15 хоног | Хугацаа болоогүй. |
| 8 | “Говь-Алтай АЗЗА” ТӨХК | 2023-2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаа | IV улиралд | 15 хоног | Хугацаа болоогүй. |
| 9 | “Талын зам” ТӨХК | 2023-2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаа | IV улиралд | 15 хоног | Хугацаа болоогүй. |
| **2.Төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт** | | | | | |
| 1 | “Улсын авто замын сан” | 2023 оны худалдан авах ажиллагаа, төсөв санхүүгийн үйл ажиллагаа | I улиралд | 15 хоног | Сайдын 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/325 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Улсын авто замын сан”-д төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж 4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | албан шаардлага, 5 зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн биелэлт 90 хувьтай байна. |
| 2 | “Улаанбаатар төмөр зам” ХНН | 2023 оны үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, төсөв санхүүгийн үйл ажиллагаа | I улиралд | 15 хоног | Сайдын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/47 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн 2023 оны үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, төсөв санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын ажлыг Сангийн яамтай хамтран хийж гүйцэтгэн 24 зөвлөмж өгч ажилласан. |
| 3 | Харьяа байгууллагууд | Үндэсний аудитын газрын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих | II-IV улирал | Улирал бүр | 1.Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч, санал хүргүүлсэн.<br><br>2.Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аудитын зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь байршуулахтай холбогдуулан харьяа байгууллагуудад 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 03/2707 дугаар албан бичгийг хүргүүлж, аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. |

---ooOoo---